

ДеФакто **ТОЙМ**

АРБИТРААС ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭРИЙГ
БИТҮҮМЖЛЭХ ШИЙДВЭР ГАРГАЛАА

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАР БУЦААД 10% БОЛЛОО

MOODY'S: МОНГОЛЫН ЭДИЙН
ЗАСГИЙН ТӨЛӨВ

АН ЖАГСААЛ ЗОХИОН
БАЙГУУЛЛАА

VI НҮҮРТ

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Б.БАТЧУЛУУН

Философийн ухааны доктор

**ХҮН ӨӨРӨӨ ЭГОИСТ
МӨН ЧАНАРТАЙ**

**ГЭХДЭЭ ЭГОИСТ БАЙНА АА ГЭЭД ЯГ
ӨӨР ШИГЭЭ ЭГОИСТ БАЙХ ХҮНИЙ
ЭРХИЙГ Л ЗӨРЧИЖ БОЛОХГҮЙ**

IV НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

УЛААН-ҮДИЙН

Тэмдэглэл

Орос Монголын иргэд 2014 оны 9-р сараас визгүй зорчих болсноор олон мянган хүн харилцан айлчилж, аялал жуулчлал, худалдаа бизнес идэвхжиж эхэлжээ.

II НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

|

ЗОРИГЖУУЛНА

|

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2018.02.07, №33

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ БУС, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn





№417

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>



УЛААН-ҮДИЙН

Тэмдэглэл

Орос Монголын иргэд 2014 оны 9-р сараас визгүй зорчих болсноор олон мянган хүн харилцан айлчилж, аялал жуулчлал, худалдаа бизнес идэвхжиж эхэлжээ. Хойд хөрштэй холбосон 3485 км хилийн шугамын бараг гуравны нэг нь Буриадын Бүгд Найрамдах Улсад ноогддог. Оросын Холбооны Улс 83 нэгжээс бүрддэгийн 21 нь өөрийн үндсэн хууль, засгийн газар, хэлтэй гэхдээ холбооноос гарах, бие даах эрхгүй “бүгд найрамдах улсууд” байдаг.

Буриадын газар нутаг нь монголоос дөрөв, хүн ам нь гурав дахин бага буюу 1 сая хүрэхгүй, дөрөвний нэг нь зөвхөн буриад, дийлэнх нь оросууд, цөөхөн

бусад үндэстнүүд ажээ. Буриаддуудын дөнгөж арваад хувь нь эх хэлээ мэддэг, албан ёсны хэл нь орос.

Алексей Самбуевич Цыденовын тэргүүлж буй Буриадын Засгийн газар эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татах талаар идэвхтэй ажиллаж байна. Ялангуяа хөрш монголчуудтайгаа хамтран ажиллах сонирхол эрс нэмэгджээ. Хоёр долоо хоногийн өмнө А.С. Цыденов Монголд айлчилж төр засгийн удирдлага, бизнес, иргэд олон нийтийн төлөөлөлтэй уулзав. Тэрээр “дефакто” нэвтрүүлэгт оролцсон.

www.jargaldefacto.com/article/aleksei-sambuewich-tsiidenow

БУРИАДАД ХИЙХ БИЗНЕС

Буриадын Засгийн газар 2011 онд “Бүс нутгийн хөгжлийн сан” байгуулж, улсаа “Оросын Азийн хаалга” хэмээн нэрийдэн гадаадын хөрөнгө оруулалт татах зорилготой ажил эхэлжээ. Байгаль нуурын зүүн эрэгт аялал жуулчлалыг хөгжүүлэх, орчин үеийн дэд бүтэц барьж байгуулах тодорхой төлөвлөгөө гарган, зарим дэд бүтцийг тавиад байна. Мөн Улаан-Үдийн онгоцны буудал нь агаарын тээврийн тав дахь эрх буюу аль ч орны онгоц шинэ зорчигч аваад нисдэг болжээ.

Орос, Монгол, Хятадын Засгийн газар Евро Азийн Пекин, Улаанбаатар, Улаан-Үд чиглэлээр орчин үеийн авто замын тээврийн коридор барих гэрээ байгуулсан. Оросууд Улаан-Үд, Хиагтын авто замаа бараг дуусаад байна. Транс-Монголын авто болон төмөр зам Улаан-Үдэд Транс-Сибирийн магистралд нийлэхээс наана, замын дунд Гусинозёрск станцын дэргэд Үйлдвэрлэл-Логистикийн төв байгуулах талбай, дэд бүтцийн хамт бэлдэж хөрөнгө оруулахыг урьж байна. Улаан-Үдэд орон сууцны хороолол барих газрууд олгож байна.

Буриадад оросын цинкийн нийт нөөцийн 48,

молибдений 31, хар тугалгын 24, вольфрамын 20 хувь нь тус тус тогтоогдсон учир эдгээр металлын болон металлын бус ашигт малтмалын олборлолтыг санал болгож байна. Мөн тахианы, сүүний болон бусад олон төрлийн хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолборуудад газар олгож, бизнесийн хөнгөлөлттэй нөхцлөөр хангаж байна.

www.invest-buryatia.ru



БУРИАДААР АЯЛАХДАА

1. БАЙГАЛЬ НУУР: Дэлхийн цэвэр усны хамгийн том нөөц, 1642 метр буюу дэлхийн хамгийн гүн энэ нуур нь аялал жуулчлалын онцгой соронзон гэдгийг хүн бүр мэднэ. Зүүн эргийн ёроол нь налуу, ус нь харьцангуй дулаан, ууланд авирах, ойд зугаалах, усан онгоцоор аялах зэрэг сонирхолтой олон хөтөлбөртэй учраас гадаад, дотоодын жуулчдын тоо жилээс жилд өссөөр байна. Нуурын зүүн эргээр Улаан-Үд хотоос машинаар хоёр цаг яваад орчин үеийн, арваад дүнзэн байшин бүхий “Байкальская Риввера” зочид буудалд бууж, орос саунд тухлаж болно.

(www.baikalriviera.ru)

Монголоос жилд хагас сая хүн Алтанбулагийн боомтоор ирж дийлэнх нь Байгаль нуураар аялах болжээ. Монголын Хүннү Эйр компани өнгөрсөн зунаас галт тэрэгнээс бараг хямд үнээр Лхагва, Бямбад хоёр “Улаан” хотын хооронд 584 км зайд нисэж, машинаар хил гааль дамжин 12 цаг үргэлжилдэг аялалыг нэг цаг болгожээ.

(<http://www.hunnuair.com/en>)

2. БУЛГА: Оросын хааны тушаалаар 1916 онд байгуулагдсан Баргузины дархан цаазтай газар нь нуурын зүүн эргийн дунд орчимд оршдог. Эндхийн булганы үс нь Хаант Оросын нэрийн хуудас болж, маш өндөр үнээр олон улсын зах зээлд борлогддог байжээ. Баргузины булгыг хамгаалах, өсгөж үржүүлэх ажлыг зуун жилийн өмнө тэгж эхлүүлжээ. Ер нь Оросын нутаг 17 дугаар зууны эхнээс зүүн тийшээ өндөр хурдтай тэлж байсны бас нэг шалтгаан нь сибирийн асар их байгалийн баялаг, түүний дотор энэ булганы арьс байжээ.

(www.barguzinskiy.ru)

3. ХАЛУУН БУЛАГ: Буриадад халуун булаг (геотермальные) элбэг бөгөөд зарим дээр нь амралт, сувиллын газрууд байгуулж байна. Улаан-Үдээс Иркутск руу холбооны М-55 замаар цаг яваад Илинька гэх сууринд “Горячий бассейн” нэртэй 28 хэмийн тогтмол халуунтай, 150 см гүн, халуун булгийн ядаргаа, үе мөчний өвчнийг анагаах увидастай усан санд замын алжаалаа тайлах боломжтой.

(www.hot-basin.ru)

4. СЕМЕЙСКИЕ: Оросын хатан хаан II Екатерина Үнэн алдартны шашинд хийсэн өөрчлөлтийг эсэргүүцсэн Оросуудыг Зүүн Сибирь, Забайкалск руу 1735 онд 40 мянга, дараа нь бас хоёр ч дахин, мянга мянгаар нь хүчээр, заримыг нь сайн дураар нь нүүлгэн шилжүүлжээ. Амар мөрний сав газрыг Чин гүрнээс булааж эзэгнэх шаардлага гарсан байлаа. Тэдний

олонх нь Буриадын нутагт суурьшин газар тариалан эрхэлж, малчин буриадуудтай харилцан ашигтай хамтран ажиллах болжээ. Өнөр олуулаа, гэр бүлээрээ ирсэн учир тэднийг сибирьт “семейские” гэдэг болжээ. Оросын түүхэнд тэднийг шашныхаа хуучин ёс заншлыг өөрчлөхийг хүсээгүй тул “старообрядцы” гэдэг. Тэд жишээ нь шинэ журмын дагуу гурван хуруугаараа биш (щепётники), урьдынхаараа хоёр хуруугаараа (двухперстники) бурхандаа мөргөх зэрэг хуучин ёс, заншлаа авч үлджээ.

Одоог хүртэл хадгалж ирсэн тэдний уламжлалт ёс, дуу хуур, ахуйтай танилцах, улмаар оросын соёл, заншлыг танин мэдэх, хүнд бэрх түүхийг нь ойлгох ховор боломж жишээ нь Новая Брянь (Заиграевский район) тосгонд байна. (<http://b-etno.ru>)

5. ИТГЭЛ ХАМБЫН ДАЦАН: Улаан-Үдээс баруун тийш 36 км зайд буй Ивольгийн хөндийд сүсэгтэн олны хандиваар 1945 онд барьсан Хамбын сүм бий. 1930-аад онд зөвлөлтийн коммунистууд буриадын бүх сүм, хийдийг устгаж шатааснаас хойш босгосон энэхүү анхны хийдийг тойроод эдүгээ бурхны шашны сэргэн мандалт ид өрнөж байна. Ялангуяа 1927 онд гэрээслэлийнх нь дагуу хуш модон хайрцганд завилуулан оршуулаад, 75 жилийн дараа гаргасан ч, өөрчлөгдөөгүй XII Пандит Хамба лам Итгэлийн биеийг байршуулснаас хойш монголчууд төдийгүй олон зуун мянган сүсэгтэн очиж мөргөдөг болжээ.

(<https://www.culture.ru/institutes/1642/ivolginskii-dacan>)

Улан-Үд хот. 2018.02.02





Б.БАТЧУЛУУН

Философийн ухааны доктор

ХҮН ӨӨРӨӨ ЭГОИСТ МӨН ЧАНАРТАЙ

ГЭХДЭЭ ЭГОИСТ БАЙНА АА ГЭЭД ЯГ ӨӨР ШИГЭЭ ЭГОИСТ БАЙХ ХҮНИЙ ЭРХИЙГ Л ЗӨРЧИЖ БОЛОХГҮЙ

Балдандоржийн Батчулуун нь Монгол Улсын Их Сургуульд Философийн ухааны докторын зэргээ хамгаалсан ба тус сургуульд 10 жил багшилсан. Энэтхэг улсын Неругийн Их Сургууль, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нээлттэй нийгэм хүрээлэн, Монголын Либертари сан гэх мэт олон газар ажиллаж байсан туршлагатай ба 2006 оноос чөлөөт судлаачаар ажиллаж байна. Философи, эрх чөлөө, сэтгэлгээ зэрэг сэдвээр хэд хэдэн ном бичсэн ба 10 гаруй ном хянан тохиолдуулсан байна.

Д.Ж: Сайн байна уу, та? Хувь хүний эрх чөлөө хамгийн чухал гэж та ярьдаг, бичдэг. Энэ чиглэлээр докторын зэрэг хамгаалсан. Хувь хүний эрх чөлөө гэдэг чинь нийгмийнхээ эрх чөлөөнөөс түрүүнд нь байдаг гэсэн энэ ойлголт монголчуудын хувьд шинэ ойлголт. Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгнийхээ төлөө гэж хүмүүс мөн ярьдаг. Энэ үзэл бодлыг та өөрийнхөө зүгээс юу гэж тайлбарлаж байна вэ? Зөв юм уу, буруу юм уу?

Б.Б: Барууны оронд байсан ойлголт л доо. Индивидуализм, Колликтевизм хоёрын алийг нь дээдлэх вэ гэдэг л. За яахав, манай дээр шилжиж ирэхээрээ хувь хүн төр хоёрын харьцаан дээр яригдана. Ер нь төр дээрээ байх ёстой юм уу? Хувь хүн нь тэргүүнд тавигдах ёстой юм уу? гэдгээр илэрч байгаа юм л даа. Түүхэн уламжлалаар аваад үзвэл Чингисийн төр ч гэдэг юм уу? Төр бол хамгийн хүчтэй зүйл. Еврази менталитет гэж ярьдаг даа, төрийг дээдэлдэг. Тэгээд 90 оноос хойш л үгүй юм байна аа. Хувь хүн түрүүнд нь байх ёстой юм байна. Хувь хүмүүс өөрсдийн эрх ашгийг хамгаалахын тулд төрөө бий болгодог. Энэ ойлголтыг л цохон тэмдэглэсэн хэрэг л дээ.

Д.Ж: Тэгэхээр энэ ойлголт хувийн өмчтэй яаж холбогдож байна вэ?

Б.Б: Ер нь хүний төрөлх 3 эрх гэж байгаа. Манай ийм хуулинд чиний ийм эрхийг заагаад өгчихсөн гэж ярьдаг. Тэгвэл эрх гэдэг чинь төрмөл зүйл. Тэрийг хуулиар бий болгодоггүй. Хүн болж төрсөн л бол амьд байх ёстой. Амьдрах эрхийг нь хэн ч зөрчиж болохгүй. Хүн эрх чөлөөтэй байх ёстой. Гуравдугаарт нь хувийн өмчтэй байх ёстой. Хүнд байдаг эдгээр зүйлийг үгүй хийсэн тэр зүйл чинь социализм шүү дээ. Чи бол юу ч биш, нийгэм л гол. Ер нь хүн өөрөө эгоист мөн чанартай. Гэхдээ эгоист

байна аа гээд яг өөр шигээ эгоист байх хүний эрхийг л зөрчиж болохгүй.

Д.Ж: Төр байсан байгаагүй амьд байх, эрх чөлөөтэй байх, хувийн өмчтэй байх гэсэн гурван эрхтэй төрж байна. Тэгэхээр төр ямар түвшинд нь хэрэг болоод байгуулагдсан юм бэ?

Б.Б: Хүний эрх чөлөөтэй байгаа явдал нь бодит амьдрал дээр илрэх практик илрэл байх ёстой гэнэ л дээ. Аман дээрээ манай төр шиг чи эрх чөлөөтэй, монголын 3 сая хүн эрх чөлөөтэй гэхчээд цаанаа эрх чөлөөгүй байлгаад байдаг? Тэгэхээр тэр нь юун дээр илэрдэг вэ гэхээр тухайн хүн хувийн өмчөө ашиглаж чадаж байна уу? Ашиглах эрх чөлөө, боломж байна уу? гэдэг дээр. Үүнийг хэтэрхий мушгиад ойлгох юм бол эрх чөлөө гэдэг чинь зөвхөн өмчтэй хүмүүсийн хэрэг юм байна, над шиг ядуу хүмүүсийн хэрэг биш юм байна аа гэж ойлгож болохгүй. Өмчгүй хүн гэж байхгүй. Адгийн наад зах нь Батчулуун гэдэг энэ бие минь байна. Муу ч сайн ч надад ажиллах чадвар байна. Энэ чинь миний өмч. Энэ өмчөө би ашиглах эрхтэй юм байгаа биз дээ гээд л ярьж байгаа.

Д.Ж: Яагаад коммунист эсвэл социалист систем угаасаа унах ёстой байсан бэ гэвэл яг таны хэлсэн хувийн өмчтэй байх гэдэг эрхийг чинь үгүйсгэж байлаа шүү дээ.

Б.Б: Хүний мөн чанарт шингэмэл зүйлийг үгүйсгэж байсан. Ер нь улсын өмч гэдэг чинь эдийн засгийн ойлголт биш л дээ. Хувьд очоогүй өмчийн хувьд тухайн өмч том байх тусмаа муу, сайн “юм” орох нь их байгаа юм шиг. Хувийн өмчид бол шахааны “юм” оруулахгүй шүү дээ.

Д.Ж: Төрийн өмч гэж байхгүй. Намын өмч л байгаа. Төр биш өрсөлдөөн зах зээлийг хөгжүүлдэг ээ гэж. Үүнийг та яаж харж байна вэ?

Б.Б: Маш зөв. Таны ярьснаар намуудын ивээлд байгаа зүйлүүд олон байх тусам амьдрах чадваргүй юмнууд амьдраад байгаа юм аа. Амьдарч байгаагийн гол асуудал нь тэр хэрээрээ нийгмийн баялгийг устгаад над мэтийн хүмүүс нь ядуу амьдраад байгаа байхгүй юу. Жинхэнэ өрсөлдөөнөөр бол тухайн зүйлийг бүтээж чадах компани л авах ёстой. Ер нь манай энэ хоёр нам амьдрах чадваргүй компаниудыг л амьдруулаад байгаа юм. Энэ бол нийгмийн баялгийг сүйтгэж байгаа хамгийн том гайтай үзэгдэл.

Д.Ж: Үүнийг чинь Чехийн зохиолч Михаил Клима гэдэг хүн Демократура гэж хэлсэн байна лээ. Демократие нэрээр хүмүүс гарч ирээд Дектатур тогтоогоод хүмүүсийг ядууруулах нөхцлийг бий болгоод байна аа гэж ярьж байгаа юм. Үүнийг та яаж харж байна вэ?

Б.Б: Энэ бол төрийн оролцооны гай юм. “Одоо бид чинь хийж байгаагаас нь аваад хийгээгүйд нь өгдөг системд орчихоод байгаа юм биш үү?” гэсэн үг байдаг. Асар олон хүнээс бага багаар цуглуулаад өөртөө байгаа цөөн хүмүүст маш ихээр тараадаг систем болчихоод байна аа гэж байгаа юм.

Д.Ж: Тэгэхээр хоёулаа ингэж харъя. Та тэгэхээр амиа бодъё, хүүхдүүдээ гадагш нь гаргая гэж ярьж байна. Тэгэхээр чинь боломжтой хүнээ гадагшаа гаргаад, боломжгүй харанхуй бүдүүлэг хүмүүс нь энд үлдвэл энэ нийгэм чинь яах вэ? энэ улс орон чинь яах вэ?

Б.Б: Миний хувьд бол юун улс орон, өөрийгөө л дөнгөж авч явж байна шүү дээ. Улс надад боллоцоо өгөхгүй байх юм бол ингэж л амиа бодохоос өөр аргагүй. Ингэж амиа бодсоноороо хэн нэгнийг хэзээ ч хохироогоогүй. Тийм биз? Өөрийнхөө амьдрах арга замыг хэнийг ч хохироохгүйгээр, төрөөс гуйлгүйгээр, хэн нэг танил талыг харалгүйгээр олоод авч байгаа хэрэг шүү дээ. Үүнийг буруутгах юм бол амьдрах хэрэггүй гэж хэлснээс ялгаа байхгүй.

Д.Ж: Одоо тэгэхээр хоёулаа өөрсдийгөө мартчихъя. Та бид нартай адилхан гурван сая хүн байна шүү дээ. Энэ хүмүүсийн хувь заяаг та яаж харж байна? Ингээд орчих юм уу?

Б.Б: Жишээлбэл үүнийг та нарын төлөө хийнэ гээд тэнд хүмүүс сонгочихоод байна. Ерөөсөө капитализм гэдэг чинь хүн өөрөө өөрийгөө, гавьяагаа ч, ялаа

ч өөрөө даахыг хэлж байгаа. Энэ улсуудыг яах вэ гээд байх юм бол төрд бүх юмаа даатгадаг хуучин социалист систем рүүгээ ороод байна гэсэн үг. Тэгэхээр оюун санаагаараа энэ үзэгдэлд дасах ёстой. Миний амьдарч байгаа чинь миний л амьдралын үр дагавар. Энэ нийгэмд чинь жоохон бодолтой байхгүй бол болохгүй юм байна. Жоохон нухацтай байхгүй юм бол болохгүй юм байна гэж хандахыг хэлж байгаа юм.

Д.Ж: За би яг энэ санааг л гаргуулах гээд байсан юм. Аль нэг хүн очоод та нарыг гэрэлтүүлээд өгнө гэж битгий хүлээ. Өөрөө хичээ. Дараагийн ярих асуудал бол юмыг одоо байгаагаар нь хэлэх, дүгнэх, шүүмжлэх амархан. Асуудал нь чи үүнийг өөрчлөхөд оролцох юм уу, үгүй юм уу? Оролцоно гэж байгаа бол ямар мэдлэг мэдээлэлтэй оролцох юм? Та энэ тал дээр либертари байр сууринаас хэлнэ үү?

Б.Б: Жишээлбэл надаас дутуу амьдралтай нэгэн байлаа гэж бодоход тэрэнд чинь зааж зааварлаад байх нь бүдүүлэг үзэгдэл л дээ. Ер нь хүнд, амьдралд нь их зөвлөгөө өгдөг хүн чинь өөрийгөө тэр хүнээс дээгүүр тавьсных нь илрэл байдаг байхгүй юу. Яахав, би өөрийнхөө үзэл бодлыг хэлж олон ярилцлага өглөө, ном бичлээ. Үүнээс өөр яах ч арга байхгүй. Заримдаа ч хаданд хашгирч байгаа юм шиг л болох юм байна шүү дээ.

Д.Ж: Тийм. Тэгэхээр таны номыг уншаагүй хүмүүс таныг их амиа хичээсэн хүн гэж бодож байгаа байх. Гэхдээ та бол энэ чиглэлээр их ажил хийсэн хүн гэдгийг олон жил таныг танихын үүднээс мэдэж байна. Батчулуун гуай, та бид хоёр чухал асуудлуудыг богино хугацаанд хөндлөө. Энэ дотроо Индивидуализм гэдэг чинь хөгжлийн суурь шүү. Чи өөрөө өөрийгөө хөгжүүлээгүй байж бусдад битгий заагаад бай. Мөн төр бол хамгийн бага оролцоотой байх ёстой гэдгийг ярилаа. Танд баярлалаа.

Б.Б: Баярлалаа.

2018.01.10

Дефакто ярилцлагын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Ярилцлагын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/b-batchuluun-batchuluun-baldandorj> холбоосоор үзнэ үү.

Ангилалдаа анхдагч:

- Их бие. Цэргийн зориулалтын өндөр чанартай хөнгөн цагааны хайлш
- Орчныг бүрэн хянах 360 хэмийн камер болон 4L бартааг тохиргоонд ажиллах хос камер (урд, хойд)
- Тэвшний хаалгыг алсаас нээх удирдлага
- Хийн дэртэй зорчигчийн суудлын бүс

Ангилалдаа шилдэг:

- Хөдөлгүүр: 691мм мушгих хүч 450 морины хүч
- Хамгийн бага бензин зарцуулалт
- Ачих даац: 1.5тн
- Чирэх даац: 3.6тн

Цэргийн зориулалтын өндөр чанартай хөнгөн цагааны хайлшаар хийсэн их бие нь автомашины жинг 226.8 кг-р хөнгөрүүлсэн

Захиалга авч байна. Утас: 7011-3673, 9910-8368, 9910-6507, 9911-8375, 9911-8301 www.waa.mn



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2018.02.04-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://fargaldefacto.com/category/12>

АРБИТРААС ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭРИЙГ БИТҮҮМЖЛЭХ ШИЙДВЭР ГАРГАЛАА

Лондонгийн олон улсын арбитрын шүүх дээр Эрдэнэт үйлдвэр ялагджээ. Энэ нь Иргэн Ш.Батхүү Эрдэнэт үйлдвэрийн 51 хувийг барьцаалан, үйлдвэрийн тамга, тэмдгийг ашиглан Английн Стандарт банкнаас 109 сая долларын зээлийн маргаанд ялагдсан гэсэн үг юм. Гэхдээ арбитраас 109 сая биш 51 сая доллар төлөх шийдвэр гарсан бөгөөд дөрвөн жилийн турш арбитрын маргаанд зарцуулсан 44 сая долларыг бас төлөх шийдвэр гаргасан байна. Мөн Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгийг битүүмжлэх хоногт 75 сая төгрөгтэй тэнцэх хүү төлөх шийдвэр гаргажээ.

Энэ тухай ЗГ өөрөө мэдээлэл хийгээгүй байгаа. Эрдэнэт нэгэнт л баталгаа гаргаад өгсөн учраас Жаст компани төлж чадахгүй бол Эрдэнэт төлнө гэсэн заалтынхаа дагуу хийж байгаа шийдвэр юм. Жаст группын ерөнхий захирал асан Ш.Батхүүтэй холбоотой гарын үсэг хуурамч байсан гэх мэт асуудал үүсэж, түүнийг баривчилсан ч хэдэн сарын дараа эрүүл мэндийн шалтгааны улмаас суллаж, ахин нэг жилийн дараа өршөөлийн хуульд хамрагдан асуудал шийдэгдэж байсан. Гэвч Стандарт банк энэ хэргийн араас явсаар байгаад, одоо МУ-ын төрийн өмчит Эрдэнэт үйлдвэр 100 орчим сая доллар төлөх үүрэг хүлээгээд байна.

Үүнээс үүдээд эхлээд олон улсын арбитрын шүүхийн дараа яах вэ? дараа нь энэ хэрэг яагаад бий болов? сүүлд нь энэ хэргээс сэргийлэхийн тулд яах байсан бэ? гэсэн асуулт тавигдана. Хэрэг яагаад үүссэн бэ гэдэгт 2008-2012 оны хооронд Жаст групп Стандарт банкнаас зээл авч хэсэг хэсгээр нь зээлийн шугам нээсэн. Нийт 6 удаа 20,30 сая доллар аваад л төлөөд л дахин бүтэц хийгээд яваад байсан юм байна л даа. Жаст групп бол манай нефть импортлогч компани байсан ба дизель түлшээ Эрдэнэтэд, төмөр замд нийлүүлдэг байсан. Гэтэл Эрдэнэт бас төмөр замын үйлчилгээг авдаг ба тэр бүр төмөр замд өөрийн үүрэгт төлбөрөө төлж чаддаггүй байсан бөгөөд Жаст групп төмөр замд төлөх

үүргийг нь гүйцэтгэж оронд нь зэсийн баяжмал авахаар болсон юм байна. Энэ схем явсаар байгаад Жаст групп нефть импортлохын хажуугаар зэсийн баяжмал зардаг болсон. 2012 онд төр засаг солигдоод, ялсан нам нь өөрийн хүмүүсээ суулгадаг “ёсоор” Жаст группын энэхүү схемд нь саад учруулсан юм байна. Энэ зогсож байгаа урсгал нь хэдэн арван сая долларынх тул Стандарт банк шүүхэд өгсөн юм. Монголын хувийн компани, төрийн компаниудтай ийм ойрхон ажилладаг энэ схем улс төрийн дэмжлэггүй явахгүй.

Гадаадын арбитрын шүүхийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1958 онд бий болсон Нью Йоркийн конвенц гэж байдаг бөгөөд үүнд Монгол улс 1994 онд нэгдсэн юм байна. Энэхүү конвенцийн дагуу бол арбитрын шүүхийн дараагийн алхам нь манай улсын шүүхэд хандах ёстой. Мэдээж энэ нь цаг хугацаа авна, монголчууд тэр гэрээг нь эх хувиар нь авах байх, тэгэхээр гарын үсэг зурсан эсэхээ тодорхой болгоно байх. Ямар ч байсан МУ энэхүү төлбөрийг төлөх ёстой ба эхний ээлжинд төлөөд дараа нь Жаст группээс буцаан нэхэмжлэх ёстой болно. Гэтэл Жаст групп Хадгаламж банкыг худалдаж авсан байснаа зарах гэхэд нь төр зөвшөөрөл өгөөгүй. Тэгээд төр Хадгаламж банкыг хураагаад авсан. Жаст группээр өөрөөр нь төлүүлж гэхэд тэдний хамгийн том өмчийг нь төр хураагаад авчихсан гэсэн үг. Төрийн банкны дотор байгаа Хадгаламж банкны үлдсэн хөрөнгөөр үүнийг төлүүлэх ёстой гэж бодож байна. Энэ бол Монгол улсын нэр хүндтэй холбоотой асуудал ба Монгол улсын хэрхэн ажиллаж байгааг харуулж байгаа тусгал юм.

Дараагийн асуулт болох үүнийг ахин гаргахгүйн тулд яах вэ гэвэл төрийн өмчит компаниудыг хувьчлахгүй бол төрийн компаниуд үндсэндээ намуудад хувьчлуулчихсан байгаа. Иргэд бид улс төрийн намуудыг хянах ёстой, төрийн өмчөө эзэнтэй болгохгүй бол нам эзэмшээд байгаа гэдгийг харуулсан үйл явдал боллоо.

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР БУЦААД 10% БОЛЛОО

УИХ-ын нэгдсэн чуулганаар Хувь хүний орлогын албан татварын өөрчлөлтийн хуулийг хэлэлцэж 65,9 хувийн саналаар баталсан. 2017 оны 4-р сард баталсан өөрчлөлтөөр татварын шатлалт тогтолцоог нэвтрүүлэхээр тусгасан байснаа ийнхүү өөрчилж нэг шатлалтай буюу 10 хувийн татварт буцаж шилжлээ. Уг шийдвэрээ тайлбарлахдаа иргэдийн нуруунд татварын ачаалал өндөр болохоос сэргийлж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх зорилготой гэжээ.

Уг нь судалгаанд тулгуурлаж хууль гаргах ёстой гэсэн хуулийн заалт байгаа. Дэлхий дээр дандаа арван хувь гэж татвараа тогтоосон 40 гаруй улс байгаа. Тооцоонд ч

амархан, энэ 10 хувийн татвар гарснаар Монгол улсад бизнес идэвхжиж байсан удаатай. Иргэдийн эсэргүүцэл, мөн шатлалтай болсноор компаниуд хүмүүсийнхээ цалинг багасгаж эхэлсэнтэй холбоотойгоор буцаасан. Мөн урьдчилаад харахад орж ирэх орлого нь хуучнаасаа дээрдэхгүй байсантай холбоотой. Ер нь татвар нэмэх тусам орлого багасдаг нь бичигдээгүй хууль, үүнийг Армен муруй гэж хэлдэг. Төрийн татвар багасахаар татварын тэлэх хүрээ томордог. 10 хувийн татварт хүмүүсийн сэтгэлзүй таатай байдаг бөгөөд үүн дээр үндэслээд тэдний санхүүгийн үйл ажиллагаа ил тод байх магадлал өндөр. Энэ хэмжээгээр далд эдийн засаг нь багасан, өрсөлдөх чадвар ч нэмэгдэнэ.

MOODY'S: МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

Мүүдис агентлагийн гаргасан дүгнэлтээр монголын эдийн засгийн гол бүтээгдэхүүнүүдийн үнэ ойрын жилүүдэд тогтвортой байх бөгөөд 2021 онд 7 хувьд хүрч өснө гэжээ. Мүүдис агентлагийн тооцооллоор ирэх онд төлөх гадаад өрийн хэмжээ гадаад валютын нөөцөөс 50 хувиар илүү байна. Мөн Монгол улсын Засгийн газрын өр ДНБ-ий 81 хувьтай тэнцэж байгаа нь асуудал дагуулж байна. Тиймээс ОУВС-ийн бүтцийн өөрчлөлтийн төслийг цаашид амжилттай хэрэгжүүлж байж энэхүү эрсдлээс сална гэж тооцсон байна.

Moody's, Standard and Poor's, Fitch гээд гурван хараат бус байгууллага улс орнуудын хөрөнгө оруулалтын нөхцлийг дүгнэдэг. Дүгнэхдээ юуны өмнө тухайн орны гаргаж байгаа бондын хүүг хөрөнгө оруулагчдад хэлдэг. Moody's агентлаг биднийг муу байсныг бага зэрэг дээшлүүлж байгаа буюу хөрөнгө оруулахад хэцүү газар гэснийг тогтвортой байх юм гэсэн чиглэл дээр л аваачиж байгаа юм. Энэ бол тийм том мэдээ биш, арай дээшилж байгаа гэдгийг улс төрчид л их ашиглаж ярьдаг даа. Монгол улсын эдийн засаг ДНБ-ийнхээ 80 хувьтай тэнцэх гадаад өртэй ч дээшилсэн гэж дүгнэж байгаагийн шалтгаан нь гол зарагддаг бүтээгдэхүүн болон нүүрс, алт, зэсийн үнэ тогтвортой буюу өсөх учраас арай ч

дампуурахгүй, гайгүй байна гэсэн л санаа. Гадаадын хөрөнгө оруулагчид маш ухаантай хүмүүс шүү дээ. Ийм том өртэй, эдийн засаг нь уул уурхайгаасаа бүрэн хамааралтай оронд гадаадын хөрөнгө оруулагчид их болгоомжтой ханддаг.

Эдийн засгийнхаа бүтцийг өөрчлөх гээд байгаагийн учир нь төрийн оролцоог багасгах, хувийн салбарын өрсөлдөөнийг дэмжих, намуудын эдийн засагт оролцох оролцоог багасгах, намын санхүүжилтийг ил тод болгох, намдаа мөнгө авах нэрээр улсын эдийн засгийг хувь хүмүүс зарахаа болих хэрэгтэй.

Хүмүүс үнэ чөлөөлөхөөр өсөөд эхэлнэ гэж боддог. Мэдээж тийм, гэхдээ буцаад буурна. Яагаад гэвэл үйлдвэрлэсэн бүх бараагаа хүн зарах гэж авсан болохоос биш барих гээгүй. Борлогдохгүй үнэтэй бол мэдээж үнэ буурна. Яг энэ маягаар орон сууц, барилгад хандмаар байна. Ипотек зарлахын тоогоор барилгын үнэ унадаггүй, 30 мянган байшин эзнээ хүлээгээд, 170 мянган айл байранд орохыг мөрөөдөөд сууж байна шүү дээ. Энэ том зөрчилдөөнийг хиймлээр бий болгоод байна.

АН ЖАГСААЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Ардчилсан нам 2-р сарын 1-ний өдөр Засгийн газрын эсрэг жагсаал зохион байгуулсан. Ажилгүйдэл, ядуурал, татварын дарамт зэрэг бичигтэй ачаа үүрсэн жагсагчид баруун дөрвөн замаас Сүхбаатарын талбай руу алхаж ирсэн. Энэхүү жагсаалд Ардчилсан намын дарга, УИХ-д сууж буй зарим гишүүд оролцсон. Ардчилсан намын даргын хэлснээр УИХ дахь олонх цөөнхийг үл тоож байгаа гэнэ.

Мөн энэ жагсаалын үеэр АН-ынхан автобусаар хүмүүс зөөж авчирсан, мөнгө тараасан зэрэг яриа гарч байсан.

Их хурлын гишүүд, та бидний хэн нь ч үзэл бодлоо илэрхийлж жагсаж болно шүү дээ. Гэхдээ жагсаж байгаа жагсаалын үйл ажиллагаа нь агуулгатайгаа давхцаж байж хүчтэй харагддаг л даа. Энэ удаа тийм ч их давхцаагүй. Ард түмэн ядарч байна гэж байгаа ч зохион байгуулж байгаа хүмүүс нь тийм ч ядарсан хүмүүс биш байна билээ.

Хүмүүст том том ачаа үүрүүлсэн байсан. Тэр ачааг нь сайн харвал энэ хоёр нам яг тэнцүү бий болгосон ачаа байхгүй юу. Үнэхээр ард иргэд гараад жагсвал МАН, АН

ямар ч хамаагүйгээр МАНАН-ийн эсрэг жагсана. Яагаад гэвэл энэ хоёр нам ээлжилж төр бариад л энэ бүхнийг бий болгосон шүү дээ. Ер нь бол энэ хоёр нам нийлж байгаад бидний анхаарлыг татаж, сарниулж байгаа үйл ажиллагаа гэж үзэж байна.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Тоймын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/defakto-toim-2sh18-sh2-sh4> холбоосоор үзнэ үү



NEW NISSAN PATROL

☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0%**


Хүү **1.4%**

Хугацаа **84** сар

УРАМШУУЛАЛ:

-  Хамгаалтын хууца
-  Сэлбэг сервисын эрх
-  4x4 Өвлийн дугуй
-  Салманы цэцнэй хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette



Та "Дефакто Газет" цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан
 Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа
 Баг: Батхүүгийн Амар
 Отгонсүрэнгийн Билгүүн
 Өсөхбаярын Биндэръяа
 Адъяагийн Тунгалаг
 Нямаагийн Цэнгэл

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
 ☎ +976 94109342
 🌐 www.defacto.mn